



НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-д Зах зээлийн хөгжлийн мэргэжилтэн шалгаруулж авна.

Төслийн зорилго: Хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг тогтвортой дээшлүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар болон Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангаас тавьсан зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

#### Тавигдах шаардлага

1. Бизнесийн удирдлага, маркетингийн менежер болон эдийн засгийн чиглэлээр дээд боловсролтой;
2. Төрийн болон Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрт 5-с доошгүй жил ажилласан туршлагатай;
3. Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх шаардлагатай. /НҮБ-ын албан ёсны 2-с доошгүй гадаад хэлний мэдлэгтэй бол давуу тал болно/
4. Дасан зохицож уян хатан байх, аливаа үүссэн нөхцөл байдлыг үнэлж, үр дүнтэй ажиллах чадвартай;
5. Багаар ажиллах, мэдээллийн технологи хэрэглээний программ, цахим орчинд ажиллах мэдлэг, ур чадвар эзэмшсэн байх.

Дээрх шаардлагыг хангасан сонгон шалгаруулалтад орох иргэд дараах бичиг баримтыг бүрдүүлж, өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.

- Төрийн албан хаагчийн анкет
- Ажилд орохыг хүссэн өргөдөл
- Холбогдох бичиг баримтын хуулбар (боловсролын диплом, иргэний үнэмлэх, хэлний түвшин тодорхойлсон бичиг баримт)
- Өмнөх ажлын газрын тодорхойлолт
- Хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар./ажилласан жилийг нотлох зорилгоор/

Сонгон шалгаруулалтад орох иргэдийн материалыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын 704 тоот өрөөнд 2018 оны 08 дугаар сарын 29 -ны өдрийн 11 цаг хүртэл хүлээн авч бүртгэнэ.

Сонгон шалгаруулалтын талаарх мэдээлийг 51-261908 дугаарын утсаар холбогдож лавлагаа авч болно.

Эхний шалгаруулалтад тэнцсэн иргэдэд сонгон шалгаруулалт явуулах хугацааг утсаар мэдээлэх болно.